



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 46

Номгон

Аялал жуулчлалын гол чиглэл, авто зам дагуух түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах газрын байршил батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аялал жуулчлалын гол чиглэл, авто зам дагуух түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах газрын байршлыг хавсралтаар баталсугай.

2. Аялал жуулчлалын гол чиглэл, авто зам дагуух түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах газрын байршлыг Улсын тусгай хэрэгцээнд авах хүсэлтийг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний
өдрийн 46 дугаар тогтоолын хавсралт



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГОЛ ЧИГЛЭЛ, АВТО ЗАМ
ДАГУУХ ТҮР БУУДАЛЛАХ ЦЭГ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ

№	Чиглэл	Сумын нэр	Талбайн хэмжээ /га/	Солбицол х/ө	Солбицол з/у
1	2	3	4	5	6
1	Говь-Алтай - Баянхонгор	Бууцагаан	3.03	46° 10' 9.462" 46° 10' 9.487" 46° 10' 4.980" 46° 10' 4.999"	98° 43' 5.851" 98° 43' 16.118" 98° 43' 16.124" 98° 43' 5.994"
2	Говь-Алтай - Баянхонгор	Бөмбөгөр	2.99	46° 12' 9.31" 46° 12' 12.08" 46° 12' 17.55" 46° 12' 14.82"	99° 35' 13.07" 99° 35' 9.17" 99° 35' 18.09" 99° 35' 21.80"

ооо